



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хөгшөө ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОМА-2026/016/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал:
Г.Энхмаа

Утас: 77450279 99040059 Цахим хаяг: ijahaudit2020@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА	
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
3.2 АЛБАН ШААРДЛАГА	7
3.3 ЗӨВЛӨМЖ.....	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 319
тавай _____ -ны № _____ -т

Г УРВАНТЭС СУМЫН ХӨГШӨӨ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.БАТХИШИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гурвантэс сумын Хөгшөө ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн мөнгөн зарлагын гүйлгээний баримтын бүрдэл хангалтгүй, татварын өр төлбөрийг хуульд заасан хугацаанд барагдуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.7, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны 462.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны 50.5 сая төгрөг, хандив тусламжийн 59.9 сая төгрөгийн, бусад 55.6 сая төгрөгийн орлогыг хүлээн авч, дахин үнэлсэн хөрөнгийн орлого 9.8 сая төгрөг, хуримтлагдсан элэгдлийн 371.9 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч, 42.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд

4828050954
F:\2 Билэг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл Docx

хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант хугацаанд Гурвантэс сумын Засаг даргын захирамжаар хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой 6,185.8 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлсэн. Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	97,540,494.26	93,411,276.85
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,916,420.28	14,519,626.66
4	Дансны авлага	20,365,203.34	17,763,392.46
5	Татвар, НДШ-ийн авлага	74,500.00	74,500.00
6	Бусад авлага	9,777,886.00	5,856,276.00
7	Бараа материал	48,436,484.64	53,589,781.73
8	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	14,970,000.00	1,607,700.00
9	Эргэлтийн хөрөнгийн дүн	97,540,494.26	93,411,276.85
10	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
11	Үндсэн хөрөнгө	6,629,508,664.45	6,651,407,826.49
12	Биет бус хөрөнгө	24,340,612.50	24,073,425.00
13	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,653,849,276.95	6,675,481,251.49
14	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,751,389,771.21	6,768,892,528.34
15	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
16	Өр төлбөр	6,276,931,760.39	6,254,024,161.55
17	Богино хугацаат өр төлбөр	33,854,057.40	68,438,925.39
18	Цалингийн өглөг	17,684.00	17,684.00
19	Татварын өр	33,603,654.29	62,388,011.5
20	Урьдчилж орсон орлого	2,719.09	2,853,307.09
21	Бусад богино хугацаат өр төлбөр	230,000.02	3,179,922.79
22	Богино хугацаат өр төлбөрийн дүн	33,854,057.40	68,438,925.39
23	Урт хугацаат өр төлбөр	6,243,077,702.99	6,185,785,269.16
24	Бусад урт хугацаат өглөг	6,243,077,702.99	6,185,785,269.16
25	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,243,077,702.99	6,185,785,269.16
26	Өр төлбөрийн нийт дүн	6,276,931,760.39	6,254,024,194.55
27	Эздийн өмч	474,458,010.82	514,668,333.79
28	төрийн (а :Өмч	584,292,192.77	584,292,192.77
29	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	32,326,033.03	32,326,033.03
30	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	23,657,800.00	23,657,800.00
31	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(165,818,014.98)	(125,607,692.01)
32	Эздийн өмчийн дүн	474,458,010.82	514,668,333.79
33	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,751,389,771.21	6,768,892,528.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	345,694,592.95	462,248,797.65
2	Борлуулалтын өртөг	363,536,540.76	768,786,019.91
3	Нийт ашиг	31,437,059.79	(306,717,222.26)
4	Дахин үнэлсэн хөрөнгийн орлого		9,835,446.93
5	Туслах үйлдэрлэлийн орлого	16,024,229.11	50,516,875.47
6	Бусад орлого		56,457,162.92
7	Хандив тусламж нүүрс	41,204,590.00	59,872,505.00
8	Хөрөнгийн хойшлогдсон орлогын ЭЗ-рх хүлээн зөвшөөрсөн орлого	97,041,649.15	371,872,720.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	258,790,355.38	189,939,801.44
11	Санхүүгийн зардал		-
12	Бусад зардал		7,400,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(73,082,827.39)	44,678,136.63
19	Орлогын татварын зардал		4,467,813.66
20	Татвар дараах ашиг (алдагдал)	(73,082,827.39)	40,210,322.97

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хөгшөө ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	607,949,992.77	32,326,033.03	(165,818,014.98)	474,458,010.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл				-
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /			40,210,322.97	40,210,322.97
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	2025 оны 12- р сарын 31- ний үлдэгдэл	607,949,992.77	32,326,033.03	(125,607,692.01)	514,668,333.79

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хөгшөө ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	488,306,591.45	663,476,845.77
3	Бараа борлуулсан, үйлчилгээний орлого	488,306,591.45	663,476,845.77
4	Мөнгөн зарлагын дүн	550,219,484.42	656,473,639.39
5	Ажиллагчдад төлсөн	238,703,661.00	265,935,674.00
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	67,930,954.74	80,808,619.52
7	Бараа материал худалдан авахад төлсөн	46,357,302.66	142,734,275.00
8	Ашиглалтын зардалд төлсөн	33,885,242.02	96,205,719.42
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	59,225,920.00	18,790,030.00
10	Хүүний төлбөрт төлсөн		
11	Татварын байгууллагад төлсөн	60,039,304.00	42,520,872.45
12	Даатгалын төлбөрт төлсөн		
13	Бусад мөнгөн зарлага	32,349,850.00	10,603,206.38
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
15	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
16	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
17	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,727,250.00	
18	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,727,250.00)	
19	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
20	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(61,912,928.97)	10,603,206.38
21	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,916,420.28
22	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,519,626.66

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		Зөрүү
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Борлуулалтын орлого	мян.төг	345,694.59	466,142.43	462,248.80	3,893.64
Туслах үйл ажиллагааны орлого	мян.төг	16,024.23	16,257.68	50,516.88	(34,259.20)
Хандив тусламжийн орлого /нүүрс/	мян.төг	41,204.59	-	59,872.51	(59,872.51)
Хойшлогдсон орлого	мян.төг	97,041.65	179,041.65	371,872.72	(192,831.07)
Ажил үйлчилгээ үзүүлсний орлого	мян.төг	691.69	4,933.85	2,058.21	2,875.64
Нутгийн дэм	мян.төг	36,720.46	69,885.71	53,548.72	16,336.99
ҮАБус орлого /үнэ тогтоосон хөрөнгийн/	мян.төг	11,866.85	11,866.85	9,835.45	2,031.41
Бусад орлого	мян.төг	-	-	850.68	(850.68)
Нийт борлуулалт	мян.төг	549,244.07	748,128.17	1,010,803.96	(261,825.10)
Шатах тослох материал	мян.төг	19,078.99	32,834.77	22,361.90	10,472.87
Нүүрс	мян.төг	45,779.37	228,500.00	58,117.50	170,382.50
Урсгал засварын зардал	мян.төг	33,170.56	15,700.00	16,970.21	(1,270.21)
Туслах үйл ажиллагааны үндсэн зардал	мян.төг	18,979.15	14,897.05	36,427.33	(21,530.28)
Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	10,785.00	13,800.00	13,809.64	(9.64)
Хог ус газрын төлбөр	мян.төг	137.91	3,600.00	486.60	3,113.40
Үндсэн болон нэмэгдэл цалин	мян.төг	247,288.33	440,775.09	325,079.51	115,695.57
НДШимтгэл	мян.төг	33,376.58	63,912.39	44,156.98	19,755.40
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	мян.төг	5,916.62	12,550.00	3,285.91	9,264.09
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	мян.төг	2,170.85	2,986.40	14,561.85	(11,575.45)
Бичиг хэргийн зардал	мян.төг	496.80	960.00	1,547.87	(587.87)

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Хөгшөө ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Албан томилолт	мян.төг	1,770.00	2,700.00	600.00	2,100.00
Албан татвар төлбөр хураамжийн зардал	мян.төг	857.01	2,134.24	729.14	1,405.10
Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг	134,920.23	174,835.76	47,527.97	127,307.80
Үндсэн хөрөнгийн элэгдэл/Хойшлогдсон орлогоор бүртгэгдсэн хөрөнгийн /	мян.төг	-	-	266,255.79	(266,255.79)
Шуудан холбоо	мян.төг	1,031.02	1,260.00	239.73	1,020.27
Сургалт	мян.төг	7,820.20	8,800.00	7,582.60	1,217.40
Цахилгааны зардал	мян.төг	38,755.95	42,739.21	87,277.93	(44,538.72)
тээврийн зардал	мян.төг	7,275.00	8,000.00	6,962.00	1,038.00
Цэвэрлэгээ үйлчилгээ зардал	мян.төг	92.00	-	174.91	(174.91)
Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал	мян.төг	12,625.33	1,350.00	4,570.45	(3,220.45)
бусад зардал	мян.төг	-	-	7,400.00	(7,400.00)
Нийт зардал	мян.төг	622,326.90	1,072,334.91	966,125.82	106,209.09
Нийт ашиг/алдагдал	мян.төг	-	(324,206.73)	44,678.14	(368,884.87)
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	-	-	-
Ажиллагсдын тоо	хүн	12.00	13.00	13.00	-
Нийт цалингийн сан	мян.төг	247,288.33	440,775.09	325,079.51	115,695.57
Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	1,717.28	2,825.48	2,083.84	741.64
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	Мян.төг	0.32	0.11	0.05	0.06
Хөрөнгө оруулалт	мян.төг	20,200.00	75,905.80	11,000.00	64,905.80
Нийт авлага	мян.төг	30,217.59	20,000.00	23,694.17	(3,694.17)
Нийт өглөг	мян.төг	6,276,931.76	6,253,077.70	6,254,215.83	(1,138.13)
Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	33,854.06	10,000.00	68,438.89	(58,438.89)
Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	6,243,077.70	6,243,077.70	6,185,776.94	57,300.76

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй.

Аудитаар нийт 48,013.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 10,273.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 37,740.4 мянган төгрөгийн зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 48,013.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 41,790.6 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.2 АЛБАН ШААРДЛАГА

Илрүүлэлт: Тайлант хугацааны эцэст 9,491.7 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн албан татвар, 28,248.7 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын өр төлбөрийг барагдуулаагүй, татварын төлбөр тооцооны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.3 ЗӨВЛӨМЖ

Илрүүлэлт 1: Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүн, Ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүн 7,255.5 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, хүчин төгөлдөр баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: Няравын тайланд 3,018.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон зарлагдсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж, баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүн, Ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүн 7,255.5 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	7,255.5					1	7,255.5				
Няравын тайланд 3,018.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон зарлагадсан зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, шаардах хуудас, орлого, зарлагын баримт гарын үсэг, тамга дутуу байна. Мөн худалдан авалтын анхан шатны баримтын цахим хэлбэрийн бүрдүүлэлт хангалтгүй.	1	3,018.0					1	3,018.0				
Тайлант хугацааны эцэст 9,491.7 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн албан татвар, 28,248.7 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын өр төлбөрийг барагдуулаагүй, татварын төлбөр тооцооны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	37,740.4			1	37,740.4						
Дүн	3	48,013.9			1	37,740.4	2	10,273.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 85,816.7 мянган төгрөг, орлогын 165,938.9 мянган төгрөг, нийт 251,755.6 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.	1	251,755.6			1	251,755.6		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Гэрээ, тушаал шийдвэргүйгээр 7,383.6 мянган төгрөгийг Шинжлэх ухаан технологийн сургуульд сургалтын төлбөр төлсөн байна.	1	7,383.6			1	7,383.6		
Дүн	2	259,139.2			2	259,139.2		